

Батлав.

“Бугант нандин” ХХК-ий  
Захирал  С.Батсүх



Сэлэнгэ аймгийн Ерөө суманд орших “Вершина толгойт” алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн тайлан

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-005959

Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 3737373

ХЯНАСАН: БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН: “БУГАНТ НАНДИН” ХХК-ИЙ

АЖИЛТАН 

О.ЭНХТАЙВАН

2022 он

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

<b>ТӨСЛИЙН НЭР:</b>	“Вершина толгойт” алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
<b>ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР:</b> <b>УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ:</b> <b>РЕГИСТРИЙН ДУГААР:</b>	“Бугантнандин” ХХК 1311005108 3737373
<b>АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:</b>	MV-005959 /26.43 га/
<b>ГАЗАР ЭЗЭМШИХ ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААР:</b>	000020169
<b>ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:</b>	Сэлэнгэ, Ерөө, 3-р баг, Бугант, Геологийн хэсэг 1 тоот; Утас: 99065280
<b>ТӨСЛИЙН БАЙРШИЛ:</b>	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны нутагт орших бөгөөд Бугант тосгоны төвөөс зүүн хойш 15 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 80 км, Улаанбаатар хотоос баруун хойш 450 км зайтай.


*Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл*

№	Уртраг			Өргөрөг			UTM	
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	X	Y
1	107	25	31.17	49	29	31.15	675632.450	5484976.949
2	107	25	28.2	49	29	30.25	675573.607	5484947.236
3	107	25	25.22	49	29	28.88	675515.029	5484903.005
4	107	25	20.06	49	29	25.96	675414.141	5484809.503
5	107	25	18.49	49	29	25.08	675383.435	5484781.315
6	107	25	15.57	49	29	23.74	675326.031	5484738.051
7	107	25	12.47	49	29	22.85	675264.559	5484708.566
8	107	25	8.63	49	29	21.93	675188.231	5484677.677
9	107	25	7.12	49	29	21.4	675158.383	5484660.336
10	107	25	5.67	49	29	21.14	675129.475	5484651.372
11	107	25	4.11	49	29	20.44	675098.789	5484628.750
12	107	25	0.93	49	29	19.69	675035.567	5484603.539
13	107	24	57.26	49	29	18.41	674963.013	5484561.647
14	107	24	55.04	49	29	17.96	674918.802	5484546.320
15	107	24	53.26	49	29	17.11	674883.839	5484518.926
16	107	24	51.04	49	29	16.57	674839.717	5484500.820
17	107	24	48.05	49	29	15.13	674780.997	5484454.429
18	107	24	41.36	49	29	12.5	674649.024	5484368.911
19	107	24	39.89	49	29	11.66	674620.284	5484342.027
20	107	24	35.21	49	29	9.49	674528.285	5484272.009
21	107	24	31.42	49	29	8.16	674453.358	5484228.503
22	107	24	28.76	49	29	7.85	674400.154	5484217.220
23	107	24	28.73	49	29	7.05	674400.341	5484192.499
24	107	24	31.67	49	29	3.62	674462.870	5484088.480
25	107	24	35.14	49	29	3.55	674532.745	5484088.551
26	107	24	35.21	49	29	4.84	674532.879	5484128.429
27	107	24	40.17	49	29	4.73	674632.766	5484128.225
28	107	24	40.28	49	29	7	674632.735	5484198.388
29	107	24	44.26	49	29	6.91	674712.888	5484198.173
30	107	24	44.34	49	29	8.85	674712.579	5484258.127

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

31	107	24	50.8	49	29	8.73	674842.649	5484258.585
32	107	24	50.89	49	29	10.67	674842.539	5484318.546
33	107	24	54.37	49	29	10.58	674912.632	5484318.011
34	107	24	54.45	49	29	12.2	674912.637	5484368.084
35	107	24	59.91	49	29	12.09	675022.579	5484368.211
36	107	25	0	49	29	14.03	675022.468	5484428.171
37	107	25	2.98	49	29	13.97	675082.472	5484428.242
38	107	25	3.03	49	29	14.94	675082.516	5484458.226
39	107	25	8.99	49	29	14.81	675202.534	5484458.061
40	107	25	9.09	49	29	16.75	675202.621	5484518.028
41	107	25	16.04	49	29	16.61	675342.562	5484518.198
42	107	25	16.11	49	29	18.22	675342.372	5484567.956
43	107	25	23.56	49	29	18.07	675492.379	5484568.144
44	107	25	23.67	49	29	20.33	675492.347	5484637.998
45	107	25	30.62	49	29	20.19	675632.285	5484638.175
46	107	25	30.73	49	29	22.45	675632.250	5484708.029
47	107	25	34.2	49	29	22.38	675702.118	5484708.116
48	107	25	34.5	49	29	28.2	675702.363	5484888.018
49	107	25	31.02	49	29	28.27	675632.297	5484887.925
50	107	25	31.17	49	29	31.15	675632.450	5484976.949

**Зураг 1. АМТЗ-ийн талбайн байршил**



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан

Зураг 2. Төслийн талбайн орчны төлөв байдал



Зураг 3. Уурхайг тосгон



**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**1.1. Ордын нөөцийн тооцоо**

Вершина Толгойт алтны үүсмэл шороон орд нь олон удаагийн олборлолтын ажлын явцад хуримтлагдаж үүссэн техноген орд бөгөөд ашиглалтын үйл ажиллагааны явцад байгуулагдсан хаягдлын аж ахуй болох нуур, гааль-эфелийн овоолго дагуу байрлах ба хөндийн дагуу 90-100 м өргөнтэйгөөр 1000 орчим м сунаж тогтоно. Орд газрын хайгуулын ажлыг 100 х 40 /м/ торын нягтралтайгаар хийж гүйцэтгэснээр сонгож авсан жишиг үзүүлэлтүүдийг хангаж захын агуулгаар хязгаарлагдсан 11 нөөцийн хэсэгшил ялгасан ба судалгаанд ашигласан торын нягтрал нь ордын нөөцийг С зэрэглэлээр тооцох үндэслэл болсон.

Хайгуулын ажлын үр дүнгээр дээрх 11 хэсэгшилд химийн цэвэр тооцоноор 32.27 кг алтны нөөц тогтоосон бөгөөд үүнээс 24.62 кг нь MV-005959 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн хүрэн дотор байрладаг. Вершина толгойт алтны үүсмэл шороон ордын геологийн нөөцийг 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр С зэрэглэлээр 230.89 мян.м3 элс буюу

химийн цэврээр 24.62 кг алтны нөөцийг тогтоож Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байдаг.

**1.2. Олборлолтын ажил**

**1.2.1. Уурхайн нээлт, ашиглалтын дараалал**

Вершина толгойт уурхай нь хөрс хуулалт багатай бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент дунджаар 0.4 м3/м3 байна. Уурхайн нээлтийг С-1 блокоос эхлэн нээнэ. Уурхайн нээлтээр нийт 11.4 мян.м3 уулын цулын ажил хийгдэнэ. Үүнээс хуулах хөрсний хэмжээ 7.25 мян.м3, бэлдэх элсний нөөц 4.2 мян.м3 байна.

**1.2.2. Уурхайн бүтээгдэхүүн гаргалтын тайлан**

Талбайн хэмжээнд олборлолтын үеийн элсний хаягдал бохирдол тооцоноор, угаах элсний хэмжээ нийт 251.3 мян.м3, олборлох алтны хэмжээ 23.64 кг болж байна. Уурхайн олборлолтын болон элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжийн хүчин чадал нь уг ордыг 1 жилийн дотор бүрэн ашиглахаар байна. Иймд уурхайн хүчин чадлыг жилд 23.64 кг алт олборлох хүчин чадалтай байхаар тусгалаа. Олборлолтын явцад хуулсан хөрсийг түр гадаад овоолго болон дотоод овоолгод шууд байршуулах ба олборлосон элсийг элс угаах талбайд тээвэрлэн хүргэнэ. Уурхайн бүтээгдэхүүн гаргалтын тайланг дараах хүснэгтэд үзүүлээ.

*Хүснэгт 2. Уурхайн бүтээгдэхүүн гаргалтын тайлан*

№	Үзүүлэлт	Нэгж	1-р жил
1	Элс олборлолт	мян.м3	221.6
2	Дундаж агуулга	мг/м3	118
3	Алтны хэмжээ /х.ц/	кг	23.64
4	Хөрс хуулалт	мян.м3	91.06
5	Хөрс хуулалтын дундаж коэф	м3/м3	0.41
6	Нийт уулын цул	мян.м3	312.62

Уурхай нь хөрсний түр гадаад овоолго болон дотоод овоолготой байх бөгөөд овоолгын хажуугийн өнцөг 33 градус байхаар тооцсон. Ашиглалтын 1 жилийн хугацаанд сийрэгжсэн эзлэхүүнээр шууд байрших дотоод овоолгын хэмжээ 99.37 мян.м3, гадаад түр овоолгын хэмжээ 5.34 мян.м3 тус тус байна.

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**1.2.3. Олборлолтод ашиглах тоног төхөөрөмжүүд**

*Хүснэгт 3. “Бугантнандин” ХХК-ийн уулын үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт*

№	Нэр	Марк	Тоо ширхэг
1	Экскаватор	Doosan DX500	1
2	Экскаватор	CAT-320B	1
3	Экскаватор	Hyundai 3000 LC	1
4	Экскаватор	Hyundai R4700LC-7	1
5	Экскаватор	Doosan55	1
6	Экскаватор	Hyundai 2900LC-3	1
7	Ковш	XCMG ZL50	1
8	Автосамосвал	HOWO 290	4
9	Бульдозер	XCMG TY160B	1
	Нийт		12

**БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**2.1. Газарзүй**

Физик-газар зүйн дүүргэчлэлээр Хангай-Өвөр Байгалийн уулархаг мужийн Хэнтийн нурууны дүүргийн Умард Хэнтийн бэсрэг уулсын тойрогт хамрагдах Толгойт, Сангийн гол, Шавартын голын уулзвараас дээш Толгойтын голын хөндийн нарийсаж буй дээд хэсэгт оршдог.

**2.2. Ус зүйн хувьд**

Төсөл хэрэгжих талбай нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсацгүй ай савд ай савд багтана. Монгол орны усны сав газар хагалбарын дагуу 29 ай савд хуваасан байдаг. Төсөл хэрэгжих талбай нь Ерөө голын сав газарт хамаарч байна. Ашиглалтын талбай нь усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй 17.46 га давхцалтай. Иймд хууль эрхзүйн дагуу таван талт гэрээг байгуулсан байна. Гидрогеологийн дүүрэгчлэлийн хувьд Хойд системийн Хэнтий-Хангайн дүүргийн Сэлэнгийн бүсийн Ерөөгийн дүүрэгт хамрагдана. Газрын доорх болон гадаргуугийн усны үндсэн тэжээгдэл нь агаарын хур тунадас бөгөөд газар доорх усны түвшний хэлбэлзэл нь орж байгаа хур тунадасны хэмжээтэй шууд хамааралтай байдаг. Талбайд болон түүний ус хураах савны хэмжээнд өмнөх судлаачид орчин үеийн дөрөвдөгчийн настай аллювийн хурдас дахь ус агуулагч бүрдэл, цэрдийн хурдас дахь ус агуулагч бүрдэл, палеозойн хурдас чулуулаг дахь ус агуулагч бүрдэл гэж ялгаж иржээ. Үндсэн чулуулгийн усжилтын байдал нь харилцан адилгүй ба үндсэн чулуулгийн ан цавшилт, бутлалтын эрчмээс хамаардаг. Энэхүү нөөц бодогдсон талбайд ихэвчлэн дөрөвдөгчийн хурдасны ус агуулагч нүх сүвэрхэг иж бүрдэл тархсан учир түүний үндсэн шинж чанарын талаар товчхон дурдах нь зүйтэй гэж үзлээ. Ус агуулсан дөрөвдөгчийн хурдас нь гол горхинуудын хөндийд элбэг тархсан байдаг. Эдгээр хурдасны зузаан нь Бугант-Толгойтын депрессийн хэсэгт 30 м хүрдэг ба тусгай зөвшөөрөлт талбайн хэмжээнд дунджаар 10.2 м ба хамгийн ихдээ 19.6 м хүрнэ. Төсөл хэрэгжих уг АМТЗ-ийн талбай нь жилд 5-10мм нөхөн сэргээгдэх чадвартай бүс нутагт хамаардаг байна.

**2.3. Хөрсөн бүрхэвч**

Тус ашиглалтын талбай нь Бугант тосгоноос зүүн хойш 15км-т ойтой уулт өндөрлөг газар бүхий түүний хөндий хотгорт байрлана. Энэ нутаг нь хөрс-газарзүйн

## **Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

мужлалтаар Хэнтийн мужийн Хэнтийн төвийн 38-р тойрогт багтана. Газрын гадаргуугийн хувьд уулт өндөрлөг болон нарийн ам хөндий жалга зэргээс бүрдэх ба өгсөж уруудсан ойн хажуу налуу гадаргуутай, уул нь ойгоор битүү бүрхэгдсэн, хөндий жалга дагуу ургамалжсан, өвслөг ургамлын бүрхэц 80-90% хүрдэг байна. Өмнөх жилүүдэд энэ хөндийд олборлолтын үйл ажиллагаа явуулснаар байгалын гоо үзэмж, дүр төрх нь алдагдаж, ландшафтын эвдрэл үүсч. газрын гадаргад гүний хурдас чулуулаг ил гарах, ухаш үүсэх, өндөр овоолго-шороо, түүний дундах хэсэг хэсэг газраар нуур цөөрөм үүсч өөрчлөгдсөн байна. Уулын хажуу бэл, налууг хамарсан хөрсний хүчтэй элэгдэл, эвдрэл талбайн баруун болон зүүн хэсэгт хүчтэй явагдаж байна. Эвдэрсэн газарт болон түүний ойролцоох газрын гадарга, хөрс-ургамлын үндсэн хэв шинж үндсэндээ алдагдсан байна. Ашиглалт явуулахаар төлөвлөж буй талбайн эргэн тойронд ихэнхидээ ойн бараан болон аллювийн ширэгт, аллювийн нугын, аллювийн хайрган зэрэг хөрс зонхилон тогтворжино. Ургамлын хувьд:

Ургамал-Газарзүйн мужлалаар “Евразийн шилмүүст ойн их муж”-ийн “Дорнод Сибирийн шинэс-нарсан ойн дэд их муж”-ийн “Хэнтийн уулын тайгын муж”-д хамаарна. (Монгол Улсын Үндэсний Атлас, 2009он). Харин Н.Өлзийхутагийн (1989 он) Ургамал-Газарзүйн тойргоор Хэнтийн уулын тайгын тойрогт багтаж байна.

### **2.4. Ан амьтан**

Энэхүү төсөл хэрэгжих талбай нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших бөгөөд Монгол орны зоогеографийн мужлалаар (А.Г.Банников 1954) Хэнтийн тойрогт багтаж байна. Тус сав нутгаар амьтан судлаачдаас анх В.С.Моллесон (1995) Ерөө, Цөх голын хагалбар нутгаар гол төлөв шувуудын зүйлийн бүрэлдэхүүн, нүүдлийн ажиглалт зохиож байжээ. Жуулчин эрдэмтэн П.К.Козлов, шувуу судлаач Е.В.Козлова Хиагтаас Өргөө хүрэх замдаа Ерөө голын адгаар байсан хөхтөн, шувуудын ажиглалт хийснээ өөрсдийн бүтээлд дурдсан байдаг. Мөн А.Г.Банников (1954) Ерөө голоор 1944-1945 оны үед богино хугацааны аялал зохиож тэнд тархсан хөхтөн амьтад ба хоёр нутагтны цуглуулга, ажиглалт нийснээ нийтлүүлсэн байна. Энэ эрдэмтнээс хойш 1965-1980 онуудад Монгол-Зөвлөлтийн хамтран биологийн иж бүрэн экспедицийн шавж, загас, хоёр нутагтан, хэвлээр явагчид, шувуу, хөхтөн судлалын биеэ даасан шинэ ангиуд энэ нутагт урт, богино хугацаагаар ажиллаж байжээ.

### **2.5. Цаг агаар, уур амьсгал**

Ерөөгийн бүс нутаг нь Монгол улсын цаг уурын мужлалаар эрс тэс уур амьсгалтай, хүйтэн өвөлтэй, Орхон-Сэлэнгийн сэрүүн бүсэд багтдаг. Ихэнхдээ жилийн дундаж температур -20С байдаг. Зун халуун, өвөл хүйтэн, 6 дугаар сарын эхнээс 8 дугаар сарын сүүлч хүртэл дулаарах бөгөөд 7, 8 дугаар саруудад хамгийн дулаан болж өдөрт дундажаар 18 С-аас 20С орчим халдаг байна. 10 дугаар сараас 4 дүгээр сарын эх хүртэлх хугацаанд хүйтрэлт болох ба хамгийн их хүйтрэлт өвлийн 1, 2 дугаар саруудад дундажаар -20С-ээс -210С хүрдэг байна. Улирлын уур амьсгалын нөхцөлөөр хавар намар, өвөл зуны үргэлжлэх хугацаа хосоороо ойролцоо байгаа нь эх газрын уур амьсгалын хахир ширүүн шинжийг илтгэж байна.

Жилийн улирлын хугацаа нь тухайн үеийн цаг агаар бүрэлдэн бий болох онцлогоос хамааран зохих хэлбэлзэлтэй байх боловч жилээс жилд 3-5 хоногоос илүү хэлбэлзэхгүй.

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**2.6. Дэд бүтэц**

Толгойтын алтны бүлэг ордыг ашиглах үед Бугант тосгон, эмнэлэг, сургууль, 110 кВт-ын цахилгааны өндөр хүчдэлийн шугам, автомашины сайжруулсан зам зэргийг барьж байгуулснаар дэд бүтцийн гол гол асуудлууд бүрэн шийдэгдсэн байдаг. Уурхайд дараах дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг хийгээд байна. Үүнд: Уурхайд ажилчдын хотхон, цайны газар, амрах байр, дууш саун, оффис, амрах байр, засварын газар зэрэг барилга байгууламжууд, цахилгаан хангамж, ус хангамж, зам талбай зэрэг уурхайн дэд бүтцийг бүрэн шийдсэн. Мөн олборлолтын болон элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжүүд, ажиллах хүчнээр бүрэн хангагдсан.

**2.7. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдал**

Ашигт малтмал ашиглах MV-005959 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбай дахь Вершина-Толгойтын алтны шороон орд нь засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт, Улаанбаатар хотоос 450 км, Дархан хотоос 200 км, Бугант тосгоноос зүүн хойш 10-15 км зайд физик-газар зүйн дүүргэчлэлээр Хангай-Өвөр Байгалийн уулархаг мужийн Хэнтийн нурууны дүүргийн Умард Хэнтийн бэсрэг уулсын тойрогт хамрагдах Толгойт, Сангийн гол, Шавартын голын уулзвараас дээш Толгойтын голын хөндийн нарийсаж буй дээд хэсэгт оршдог. Сэлэнгэ аймгийн Ерөө сум нь 1924 онд Түшээт хан аймгийн Эрдэнэ чин вангийн хошууны Хүдрийн “Бэлчир” гэдэг газар Галттай нэртэйгээр 240 өрх 2039 хүн амтай буриад иргэдийн хүсэлтээр байгуулагджээ. Түүнээс хойш сумын төвийг 1925 онд Карников тосгонд 1953 онд одоогийн Тавинд шилжүүлжээ. Тус сумаас 1971 онд одоогийн Хүдэр сум, 1976 онд Жавхлант сум тус тус бие даан засаг захиргааны нэгж болон салсан түүхтэй. Тавин, Буурагчин, Бугант гэсэн 3 багийн нийт 1862 өрхөд 6567 хүн амьдардаг. 2 баг нь сумын төвд Бугант тосгон нь сумын төвөөс 75 зайд байрладаг. Ерөө сум нь Сэлэнгэ аймгийн нийт газар нутгийн 19.76 хувийг эзэлдэг бөгөөд хүн амын тоогоор Сэлэнгэ аймгийн 17 сумаас эхний 5-д, газар нутгийн хэмжээгээр 1-д ордог сум юм.



**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн  
2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Үргэлжилсэн хугацаа
1	Хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	Шимт хөрсийг уурхайн ирмэг дагууд хуулан түрж овоолно. Хуулах үржил шимт өнгөн хөрсний дундаж зузаан 0.3 м ба ашиглалтын хугацаанд уурхайгаас нийт 49.3 мян.м3 /сийрэгжсэн 64.1 мян.м3/ үржил шимт хөрс зөөгдөх бөгөөд энэ нь нийт хөрсний 70.4% болж байна. 17.4 га талбайд олборлолтын үйл ажиллагаа явагдана.	Хүчтэй	Төсөл хэрэгжих хугацаанд
2	Элс олборлолт, баяжуулалт	Геологийн тогтоц, гүний ус, агаар	Уурхайн ухаш-9.6 га, Овоолго-1.2 га, Элс угаах талбай-0.5 га, Шимт хөрс-1.1 га, ШТС-0.5 га, ЗҮТ-1.0га, Нуурууд-1.3 га, Хотхон-1.0 га, Зам-1.2 га талбай буюу нийт 17.4 га талбай эвдрэлд өртөнө.	Хүчтэй	
3	Тээвэр	Хөрсөн бүрхэвч, агаар орчин, ургамлан нөмрөг, усны нөөц	Хөрсийг уурхайн ирмэг дагуу бульдозероор түрж овоолгод байршуулах ба тээврийг дунджаар 757 м зайд хийхээр төлөвлөсөн нь жилийн хугацаанд 2000 м зам ашиглахаар байна. Дотоод замын тоосжилтыг бууруулах зорилгоор хоногт 43.2 м <sup>3</sup> /1 жилд 7.77 мян.м <sup>3</sup> / хүртэл ус ашиглана.	Дунд	
4	Овоолго	Хөрс, агаар, шимт хөрс	Хөрсний түр гадаад овоолгод нийт 2.2 га (5.34 мян.м <sup>3</sup> ) талбай дарагдана. Ил уурхайн хөрсийг авто тээврээр зөвхөн өмнө олборлосон орон зайд дотоод овоолго хийнэ.	Бага	
5	Барилга байгууламж, дэд бүтэц	Хөрс, шимт хөрс	Ажилчдын хотхон, цайны газар, амрах байр, дууш саун, оффис, амрах байр, засварын газар зэрэг барилга байгууламжууд болон Дархан хотоос Толгойтын алтны үйлдвэр хүртэл 110 кВт-ын дэд станцын нам талаас 6 кВт-ын ЦДАШ салбарлан ордын талбай хүртэл татсан дэд станц, автомашины сайжруулсан зам зэргээс бүрдэнэ. Төсөл хэрэгжих хугацаанд шинээр нэмж барилга байгууламж барихгүй тул түүнээс үүсэх сөрөг нөлөөлөл төдийлөн бага болно	Бага	

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

“Вершина толгойт үүсмэл шороон ордыг ашиглах төсөл”-ийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны менежментийн анхаарвал зохих асуудлууд болон гол чухал зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд өртөгдөх хэсгүүдэд уулын ажлын төлөвлөлт болон тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд холбогдох аргачлал, стандартын дагуу техникийн ба биологийн нөхөн сэргээлтийг явуулж орон нутагт хүлээлгэн өгөх;
- Уурхайн хаалт-нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг төслийг эхлэхтэй зэрэгцүүлэн боловсруулах, орон нутгийн иргэдээр хэлэлцүүлж, асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудаар хянуулан батлуулах;
- Уурхайн талбайд байгаль орчны үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах албан тушаалтныг томилж, байгаль орчны чиглэлээр дотоодын хяналт ба ажилчдад зориулсан сургалт сурталчилгааг тогтмол явуулж хэвших;
- Байгаль орчныг хамгаалах ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу байгаль орчны менежмент төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг өндөр түвшинд байлгах, мөн байгаль орчны хугацаат аудитыг хийлгэсэн.
- Уурхайн үйл ажиллагаа ба барилга байгууламж, ажилчдын байрнаас үүсэх хог хаягдалтай холбоотойгоор хог хаягдлын менежментийн 3R зарчмыг хэрэгжүүлж, үүсэх хог хаягдлыг багасгах, түүнийг дахин ашиглах, дахин боловсруулах ажил зохион байгуулах;
- Орчны хяналт шинжилгээг хуваарийн дагуу явуулж уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлд хяналт тавих;
- Үйл ажиллагааны явцад үүсэх орчны тоосжилтыг хамгийн бага байлгахад анхаарч ажиллах, тайлангийн холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаа.

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах”  
төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

*Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан*

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (сая.төг)	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт	
<b>АГААР МАНДАЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТАЙЛАН</b>									
Тоосжилт болон бохирдуулагчийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Уурхайн технологийн замуудыг усалж чийглэх, (тодорхой ажлын график гаргах ба хуурайшилттай үед усалгааны хугацааг ойртуулах)	Уурхайн дотоод тээврийн зам	га	2.4	Үйл ажиллагааны зардлаас		Ил уурхайг ашиглах хугацаанд буюу дулааны улиралд	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS4585:2007	
	Хүнд механизм утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах талаар засвар үйлчилгээг тогтмол явуулах, авто машины улсын үзлэгт хамруулж ажиллах	Төслийн хүрээнд, уурхайд ажиллаж буй бүх хүнд механизмуудад	Тээврийн хэрэгсэлийн тоо		10	0.3	2.0	2022	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
	Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх	Уурхайд ажиллаж буй бүх машин техникүүдэд	ш		5	Үйл ажиллагааны зардлаас		2022	ХАБЭАТ хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах	Уурхайн бүх ажилчдад	Хүн		38	ХАБЭА-н зардлаас		2022	MNS(ISO)13688:2000 MNS 3306:1991 MNS 5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах”  
төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгслүүд	ш	11	Үйл ажиллагааны зардлаас		2022	
Нийт зардал					3.0			
УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТАЙЛАН								
Төслийн талбайн ойр орчмын газар доорх усны түвшин уурхайн ус зайлуулалтын улмаас буурах	Ерөө голын сав газартай ус ашиглах гэрээ байгуулан ажиллах	Төслийн хүрээнд	м <sup>3</sup>	Ашиглах хэмжээг ээр	Үйл ажиллагааны зардлаас		Уулын ажил эхлэхийн өмнө	“Усны тухай хууль”-ийн 28.4-р зүйл
	Үйлдвэрлэлийн болон ахуйн усны хэрэглээг нарийн тооцож, ашигласан усны хэмжээгээр төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	м <sup>3</sup>	Ашиглах хэмжээг ээр	Үйл ажиллагааны зардлаас		Сар, улирлаар	БОС-ын 1995 оны 153 тоот тушаал
Газрын доорх болон ил задгай ус бохирдох Гадаргын урсацын гольдрол өөрчлөгдөх	Ахуйн бохир ус зайлуулах цооног байгуулах ашиглах, засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэх	Уурхайн ажилчдын тосгонд	ш	1	1.0	1.0	2022 буюу төсөл эхлэхийн өмнө ашиглалтанд оруулах	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. “Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982. БОА-ын тайлангийн зөвлөмжид зааснаар
	Уурхайн талбайд БИО-00 суурилуулах	Төслийн хүрээнд	ш	2	1.0	2.0		
	Унд ахуйн ус ашиглаж байгаа хэсгийн эргэн тойронд хамгаалалтын бүс тогтоох, хашаажуулах, тэмдэгжүүлэх	Унд ахуйд ашиглагдах 1ш худагт	ш	1	ҮА-ны зардалаар			
Дүн					3.0			
ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАДАРГЫН ХЭЛБЭРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ								
Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шим, чийг буурах, бохирдох, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолгуудыг MNS 5915:2008 стандартын байгуулж ажиллах	Төслийн хүрээнд, Уурхайн эдэлбэр газарт			ҮА-ны зардалаар		2022	Газрын тухай хуулийн 50-р зүйл 50.1.1 дэх заалт. MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт
	Уурхайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, хяналт тавин ажиллах	Ашиглалтын талбайд	ш	5-8	0.05	0.4	2022	
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах,	Уурхайн эдэлбэрт хяналт тавих	Төслийн хүрээнд	Тухай бүр	0.25	0.4	2022	

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах”  
төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

	бохирлогдсон хэсгийн хөрсийг саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах						хийх хөрс. Техникийн шаардлага” “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”
	Хоосон чулуулгийн овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй байршуулахаас гадна Хөрсний гулсалтаас хамгаалах, уурхайн карьерийг батлагдсан ТЭЗҮ болон УАТөлөвлөгөөний дагуу байгуулж ажиллах	Уурхайн эдэлбэрт			ҮА-ны Зардалаар гүйцэтгэх	2022	
	Алт агуулсан элсэнд эрдэс бүрдлийн шинжилгээ хийлгэж, хөрсөнд агуулагдах хүнд металлын бохирдолт нэмж ихсэхээс сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх (Геологийн төв лаборатори болон ШУТИС геологийн лабораторит шинжлүүлэх)	Уурхайн эдэлбэрт			ҮА-ны Зардалаар гүйцэтгэх	2022	MNS 5850:2008
Дүн					0.8		
<b>УРГАМАЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН</b>							
Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр ургамлан нөмрөг устгах	Уурхайн хаалтанд зориулж тухайн нутаг орны унаган ургамлын зүйлийн бүрдэлийн үрийг ашиглах Мөн талбайд алаг цоог цөөн тоогоор ургаж эхлэж буй зулзаган хуснуудыг олборлолтод өртөхөөргүй хэсгүүдэд гэмтээлгүйгээр шилжүүлэн суулгах (хээрийн судалгаагаар тоологдсоноор 18 ширхэг байсан)	Төсөл хэрэгжих талбай орчим	Төслийн хүрээнд		Нөхөн сэргээлтийн зардалаас	2022	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага” “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”
	Төсөл хэрэгжиж буй талбай орчмын ургамлын зүйлийн бүрдэл, биомасс зэрэгт тогтмол анхаарч ажиллах, хөрс талхлагдлаас үүдэн ургамлын зүйлийн бүрдэл өөрчлөгдөх хомстох зэрэгт тогтмол хяналт тавьж ажиллах, мониторинг хийж байх				ОХШХөтөлбөрт туссан зардалаар	2022	
Дүн					НСЗ+ОХШХЗ		

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН								
Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах	Төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн орчимд	удаа	Жилд 1 удаа	0.5	0.5	2022	Амьтны аймгийн тухай хууль: 6.1.7 дах заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
	Уурхай ачиж тээвэрлэх үед тээврийн хэрэгслийн хурд тогтоох, Осол гарч болзошгүй зэрлэг ан амьтан өнгөрөн гарч болзошгүй хэсгүүдэд тэмдэглэгээ байрлуулах		ш	Шаардлагатай тоогоор	ҮАЗ	ҮАЗ	2022	
	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих	Уурхайн ажилчдад	Нийт ажилчид	38 хүнд	0.5	0.5	2022	
Дүн						1.0		
Нийт дүн							6.8	

**БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН**


Уг үүсмэл шороон ордыг ашиглахдаа ордын доод хэсэг буюу 1С блокоос эхлүүлж 7с блокыг ашиглаж дууслаа .Энэ хугацаанд ашиглагдсан хоосон орон зайг дотоод овоолго хийх замаар техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 6.6 га талбайд хийлээ.Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцолыг харууллаа.

№	Талбайн хэмжээ га	х	Ү
1	6.6	674542.9334	5484254.952
2		674520.1322	5484240.437
3		674502.443	5484232.957
4		674488.3586	5484220.67
5		674475.8621	5484204.823
6		674471.9536	5484201.105
7		674411.3497	5484174.185
8		674400.34	5484192.5
9		674400.1501	5484217.205
10		674453.36	5484228.5
11		674528.3016	5484272.026

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах”  
төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

12	674574.28	5484307.02
13	674620.28	5484342.03
14	674649.02	5484368.91
15	674776.8954	5484451.77
16	674839.679	5484500.796
17	674883.84	5484518.93
18	674918.8	5484546.32
19	674963.01	5484561.65
20	674972.8575	5484567.335
21	675004.2154	5484478.678
22	674776.7216	5484291.555
23	674603.2923	5484192.414

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан



*Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн тойм зураг*



**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**




**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах”  
төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**БҮЛЭГ 7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

Олборлолтын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул, төслийн нөлөөлөлд өртсөн ба Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоох, дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутгийн байршлыг сонгох, биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн арга хэмжээг тогтоох, мониторинг хийх хөтөлбөр зохиох, төсөв, санхүүжилтийн төлөвлөгөө гаргах гэсэн үндсэн шат дараалалтайгаар дүйцүүлэн хамгаалах тайланг боловсрууллаа. Энэ жилийн дүйцүүлэн хамгааллын хүрээнд Сэлэнгэ аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газраас оноож өгсөн Ерөө сумын нутагт орших сангийн голын хөндийд хийсэн болно.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан




*Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн байгаль орчны газраас оноож өгсөн газрын сансрын зураг*

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан



*Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нөхөн сэргээлт хийхээс өмнөх үеийн фото зураг*

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан



*Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал*

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан



*Техникийн нөхөнсэргээлт хийсний дараа*

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан



*Техникийн нөхөнсэргээлт хийсний дараа*

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

*Хүснэгт 5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан*

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг (сая.төг)	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримталсан эрх зүйн баримт бичиг
1	Биологийн олон янз байдлыг сайжруулах менежментийн арга хэмжээг тодорхойлох	Нөхөн сэргээлт-2024 арга хэмжээний хүрээнд уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд өртөн нөхөн сэргээлт хийгдэлгүй эзэнгүй орхигдсон 5.4 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх	Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 04-р сарын 04-ний өдрийн №115 тоот саналын дагуу	9	48,6	2022 онд	БОННУ-ний аргачлал, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага
<b>Нийт дүн</b>						<b>48,6 сая.төг</b>	



**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

Ашигт малтмалын талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй. Уурхай нь үйл ажиллагаа явуулж дууссаны дараа 2023 онд уурхайн хаалт болон нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ.

**БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

Өмнөх жилүүдэд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн дагуу төслийн талбайд археологи хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байсан. Тус хуулийн 29.1-д зааснаар соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэг хувийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлсэн байдаг.Цаашид ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд уулын ажлыг нэн даруй зогсоож, хуулийн хүрээнд авбал зохих арга хэмжээг авч ажиллана.

**БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН**

Энэ тайланд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартуудыг энд тусгасан болно.

Уг төслийг хэрэгжүүлэх явцад уурхайлалтын ажлыг цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг аваар осол багатайгаар зохицуулж ажиллах шаардлагатай ба компаний онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллаж байна.

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Вершина толгойт алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах”  
төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн тайлан**

**Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал түүний хэрэгжилт**

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал сая.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
